



Дорнод аймгийн Аудитын Газар

Үндэсний Аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө, удирдамжийн дагуу хийсэн нийцлийн аудитын тайлан

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ ҮАГ-НАГ/2016/04-НА/



ХУУЛИЙН 3.1.1, 3.1.2-Т ЗААСАН ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ БАЙГУУЛЛАГУУД ХУУЛИЙН ХУГАЦААНД МЭДЭЭЛЛИЙГ БАЙРШУУЛАХГҮЙ БАЙНА.

Чойбалсан хот
2016 он

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:
Дорнод аймгийн Аудитын
газрын Санхүүгийн
аудитын баг

Дарга, Тэргүүлэх аудитор
Б.Болортуул Утас:
70584203

Ахлах аудитор:
Д.Нармандах
Аудитор: Б.Одхүү
Шинжээч: Б.Батжаргал

Утас: 70584207

2016 оны 12 дугаар сар
Аудитын тайлантай
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70584207 дугаарын
утас, 70584203
дугаарын факсаар
харилцана уу.

Хаяг: Дорнод аймаг,
Хэрлэн сум, 7-р баг,
аймгийн ЗДТГ-ын 2-р
байр, 2 давхар 04 тоот

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ I БҮЛЭГ: ШИЛЭН ДАНСНЫ НЭГДСЭН СИСТЕМД ТӨРИЙН ЧИГ ҮҮРЭГТ ХАМААРАХ АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭГ ХУУЛЬ ТОГТООМЖ, ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН ДЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ З ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ ЦЭС НЭЭЛГЭЭГҮЙ БАЙНА.

- 1.1 Аймгийн хэмжээнд нийт байгууллага, аж ахуйн нэгжийн 98,5 хувь нь шилэн дансны хуулийн дагуу хамрагдсан байна.6
- 1.2 Тусгай хуулиар зохицуулагддаг орон нутагт үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжүүд хамрагдахгүй байна.....6
- 1.3 Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан байгууллагууд тус аймагт байхгүй байна.....6
- 1.4 Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т заасан байгууллагууд бүрэн хамрагдсан байна.....6
- 1.5 Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч 3 өрхийн эрүүл мэндийн төв цэс нээлгээгүй байна.....7

II БҮЛЭГ: ХУУЛИЙН 3.1.1, 3.1.2-Т ЗААСАН ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ БАЙГУУЛЛАГУУД ХУУЛИЙН ХУГАЦААНД МЭДЭЭЛЛИЙГ БАЙРШУУЛАХГҮЙ БАЙНА.

- 2.1 Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээллийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.....7
- 2.2 Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.4-т заасан мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.....8
- 2.3 Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 6 дугаар зүйлийн 6.5-д заасан мэдээлэл орон нутгагт хамааралгүй.....9
- 2.4. Хуулийн 6.7-д “Нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон бусад төрийн захиргааны байгууллага нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг тухайн этгээдийн овог нэрийн хамт цахим хуудсанд байрлуулсан тухай бүр шинэчилж мэдээлнэ.” гэж заасан нь аудитын арга зүйд хамааралгүй.....10
- 2.5 Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.8-д заасан мэдээлэл орон нутагт хамааралгүй.....10
- 2.6 Хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасны дагуу Цөм сүрэг, үржлийн төв мэдээллийг иргэн олон нийтэд хүргэх үүргээ хэрэгжүүлэн ажиллаагүй байна.....10

III БҮЛЭГ: БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ТАВИХ ДОТООД ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

- 3.1 Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу аймгийн ИТХ хяналт тавьж ажиллаагүй байна..... 10
- 3.2 Хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан этгээд хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.....10

ДҮГНЭЛТ ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН ХАРИУ ЗӨВЛӨМЖ АЛБАН ШААРДЛАГА ТУШААЛ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ҮАГ	Үндэсний аудитын газар
ХК	Хувьцаат компани
ТӨХК,	Төрийн өмчит хувьцаат компани
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЭЭС	Эмийн эргэлтийн сан

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:**

Монгол Улсын Ерөнхий аудиторт УАГ болон Дорнод аймгийн Аудитын газраас 2016 онд нийлүүлэх аудит, ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон төрийн аудитын төрөлжсөн болон орон нутаг дахь салбар байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтуудын хүрээнд аудитыг хийлээ. Үүнд:

- ✓ Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан байгууллагууд бүрэн хамрагдаж байгаа эсэх;
- ✓ Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан байгууллагууд 6 дугаар зүйлд заасан мэдээллийг мэдээлж байгаа эсэх;
- ✓ Хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан этгээд хяналтыг хэрэгжүүлж байгаа эсэх;
- ✓ Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт.

Аудитын хамрах хүрээ

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан хуулийн этгээд, байгууллага, албан тушаалтны 2016 оны 01 дүгээр сарын 01-нээс 10 дугаар сарын 30-ныг хүртэлх үйл ажиллагааг хамруулав.

Үндсэн мэдээлэл:

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөөний дагуу 2015 онд 2 удаа, 2016 оны эхний улиралд шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийсэн бөгөөд аудитаар илэрсэн гол асуудлыг үндэслэл болгон 2016 оны 1-10 дугаар сард хийх аудитын зорилтыг тодорхойлсон.

Аудитын батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан аудитын зорилт, дэд зорилтуудын дагуу Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2, 3.1.3-т заасан байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүрэн хамрагдаж байгаа, тэдгээр нь хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг бүрэн мэдээлж байгаа, 8 дугаар зүйлийн 8.2-т заасан байгууллага, албан тушаалтан хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж байгаа эсэхийг аудитаар онцгойлон анхаарч үзлээ.

Аудитад Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан улсын төсвийн 43, аймгийн ТЭЗ, түүний харьяа 166, нийт 209 төрийн болон орон нутгийн төсөвт албан газар, төсөл, хөтөлбөр, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, компани, тэдгээрийн өмчийн оролцоотой байгууллагыг хамруулав.

2016 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагууд нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 7 төрлийн мэдээлэл, 3.1.2-т заасан төрийн өмчит үйлдвэрийн газар 7 төрлийн мэдээлэл, 3.1.3-т заасан хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компаниудыг 3 төрлийн мэдээлэл тус бүр оруулахаар хуульчилсан байна.

2016 оны 1 дүгээр улиралд хийгдсэн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 97,1 хувьтай байсан бол 2016 оны 10 дугаар сарын 30-ны байдлаар аудитад 209 байгууллага хамрагдан 96,7 хувьтай хэрэгжүүлж өмнөх аудитын гүйцэтгэлтэй харьцуулахад 0,4 хувь буурсан байна. (Хавсралт №1, №2)

Аудитын явцад илэрсэн зөрчилд тухай бүр залруулга хийлгэж ажилласнаас гадна нийт 281,4 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж 9 байгууллага, 18 албан тушаалтанд зөрчлийг арилгах, хугацаатай 9 албан шаардлага хүргүүлээ.

Мөн шилэн дансанд хамрагдаагүй байсан 3 өрхийн эрүүл мэндийн төвийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүртгүүлэх албан шаардлагыг тухайн төсвийн Ерөнхийлөн захирагчид өгөв.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөр, АДБОУС 100-400, 4200, Төрийн хяналт шалгалтын стандартыг баримтлан аудитын арга зүйн дагуу Шилэн дансны тухай хуулийн 3, 8 дугаар зүйлд заасан байгууллага, аж ахуй нэгжийн нэгдсэн болон өөрийн цахим хуудас, мэдээллийн самбарт байрлуулсан мэдээллийг, төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналтын хэрэгжилтийн тайлан, дансны хуулгын дүн, анхан шатны баримттай тулгах, санхүүгийн мэдээллийн самбарыг бодит байдал дээр нь очиж үзэх зэрэг аудитын горимуудыг ашиглалаа.

Аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитын шалгуур үзүүлэлт:

Аудитад дараах хууль эрхийн актыг шалгуур үзүүлэлт болголоо.

- ✓ Төсвийн тухай хууль
- ✓ Төрийн аудитын тухай хууль
- ✓ Шилэн дансны тухай хууль
- ✓ Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- ✓ Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 11-ний 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох” журам.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, аудитын менежер В.Цэнгэлмаа үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, аймгийн Аудитын газрын санхүүгийн аудитын багийн ахлах аудитор Д.Нармандах, аудитор Б.Одхүү, шинжээч Б.Батжаргал нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын хугацаа

Аудитыг 2016 оны 10 дугаар сарын 03-ны өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 12-ны өдөр дуусган, тайланг удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн дарга, Тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулж, аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагч болон ҮАГ-ын Нийцлийн аудитын газарт хүргүүлнэ.

Аудитын тайлангийн бүтэц түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, холбогдох байгууллагын санал, аудитын зөвлөмж, албан шаардлага, тайлангийн хавсралт хэсгүүдээс бүрдлээ.

Аудитын тайланд аудитын зорилтууд болох дээр дурьдсан 3 асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлс, мэдээллийг хангалттай хэмжээгээр орууллаа.

Аудитын тайланг шалгагдагч байгууллагын удирдлага, хамт олон, холбогдох удирдлагуудад танилцуулж, санал авч, аудитын тайланг эцсийн хувилбараар боловсруулан удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн батлууллаа.

I Бүлэг: Шилэн дансны нэгдсэн системд төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч 3 өрхийн эрүүл мэндийн төв цэс нээлгээгүй байна.

1.1. Аймгийн хэмжээнд нийт байгууллага, аж ахуйн нэгжийн 98,5 хувь нь шилэн дансны хуулийн дагуу хамрагдсан байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д “төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд” хамрагдахаар заасан байдаг.

Дорнод аймгийн хэмжээнд Шилэн дансны цахим мэдээллийн санд төрийн өмчит 43, аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багц болон түүний харьяа орон нутгийн төсвийн 126, аж ахуйн тооцоотой өмчит үйлдвэрийн 26, Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч 9 байгууллага, нийт 209 байгууллага хамрагдахаас 206 байгууллага буюу 98,5 хувьтай хамрагдсан байна.

1.2. Орон нутагт үйл ажиллагаа явуулдаг тусгай хуулиар зохицуулагддаг аж ахуй нэгжүүд хамрагдахгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т төрийн өмчит үйлдвэрийн газар хамрагдахаар заасан байдаг.

Дорнод аймгийн хэмжээнд Дорнод бүсийн эрчим хүчний систем ТӨХК, ИНЕГ-ын харьяа Дорнод нисэх буудал, Авто тээврийн үндэсний төвийн Дорнод салбар, Дорнод аймаг дахь Радио телевизийн газар, Цөм сүрэг үржлийн төв зэрэг үйл ажиллагаа явуулж байгаа 5 төрийн өмчит компани хамрагдсан байна.

Тусгай хуулиар зохицуулагддаг Төрийн банкны Дорнод салбар, Монголын цахилгаан холбоо ХК-ий Дорнод салбар зэрэг нь шилэн дансны нэгдсэн системд мэдээллээ бие даан байршуулдаггүй төв компани нь нэгдсэн журмаар байршуулж байна.

1.3. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан байгууллагууд тус аймагт байхгүй байна.

Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани Дорнод аймагт байхгүй байна.

1.4. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т заасан байгууллагууд бүрэн хамрагдсан байна.

Аймгийн ТЕЗ нь Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, арга хэмжээ, ажил үйлчилгээний нийт 48 нэр төрлийн 2028.8 сая төгрөгийн гүйлгээг 58 аж ахуйн нэгж байгууллагаар гүйцэтгүүлж, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлсэн байна. /Маягт 4/

1.5 Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч 3 өрхийн эрүүл мэндийн төв цэс нээлгээгүй байна.

3.1.5-д “Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллага” хамрагдахаар заасан байдаг.

Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч Асралт үйлс, Мянган жаргалан, Ягаан цээнэ өрхийн эрүүл мэндийн төвүүд Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цэс нээлгээгүй байна.

II Бүлэг: Хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагууд хуулийн хугацаанд мэдээллийг байршуулахгүй байна.

2.1. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.1-д заасан мэдээллийг бүрэн мэдээлээгүй байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д тухайн жилийн төсвийг мэдээлвэл зохих 200 байгууллагаас 196 байгууллага буюу 98 хувь, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг мэдээлвэл зохих 18 байгууллагаас 13 байгууллага буюу 72,2 хувь, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг мэдээлвэл зохих 15 байгууллага 100 хувь мэдээлсэн байна.

Тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө зэргийг Баянтүмэн, Баяндун, Гурванзагал, Матад, Цагаан-Овоо, Халхгол, Хөлөнбуйр сумдын төсөвт байгууллагууд болон Стандартчилал хэмжил зүйн хэлтэс мэдээллээгүй байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-д заасан 01-10 дугаар сарын гүйцэтгэлийг 198 байгууллага 96,6 хувьтай мэдээлсэн байна. Цөм сүргийн үржлийн төв нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүртгэлтэй боловч мэдээллийг огт байршуулаагүй байна.

Онон, Улз голын сав газрын захиргаа 04-10 сарын, Баянтүмэн хөгжил, Гурванзагал хөгжил, Хөөвөр хөгжил ОНӨҮГ-ууд 01-10 сарын, Халхгол сумын ИТХ 03-10 сарын, ЗДТГ 07-10 сарын, Стандартчилал хэмжил зүйн хэлтэс төсвийн гүйцэтгэлийн 07-09 сарын, Зэвсэгт хүчний 327 дугаар анги 09-10 сарын мэдээллийг тус тус мэдээллээгүй байгаад албан шаардлага өгч ажиллаа.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-д зааснаар дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор мэдээлвэл зохих 173 байгууллагаас 156 байгууллага буюу 90,2 хувь мэдээлж, Баянтүмэн, Халхгол, Матад, Гурванзагал, Цагаан-Овоо сумдын төсөвт байгууллагууд мэдээллээгүй байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-д зааснаар хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор мэдээлвэл зохих 198 байгууллагаас 162 байгууллага буюу 81,8 хувь мэдээлсэн, Халхгол, Цагаан-Овоо, Хөлөнбуйр, Гурванзагал сумдын ЭЭС-гууд, Баянтүмэн, Гурванзагал, Матад, Халхгол, Хөлөнбуйр, Сэргэлэн, Цагаан-Овоо сумдын ОНХС, Баянтүмэн, Матад, Халхгол сумдын төсөвт байгууллагууд мэдээллээгүй байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4-д заасан жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, 6.1.5-д төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн
ҮАГ-НАГ/2016/04-НА/ *хуудас 7*

04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор мэдээлвэл зохих 198 байгууллагаас 179 байгууллага буюу 90,4 хувь мэдээлсэн байна.

Жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг Баянтүмэн, Гурванзагал, Матад, Халхгол, Хөлөнбуйр, Сэргэлэн, Цагаан-Овоо сумдын ОНХС, Баянтүмэн, Матад, Халхгол сумдын төсөвт байгууллагууд, Стандартчилал хэмжил зүйн хэлтэс мэдээллээгүй байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5-д заасан аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор мэдээлвэл зохих 171 байгууллагаас 156 байгууллага буюу 91,2 хувь мэдээлсэн байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6-д зааснаар төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр мэдээлвэл зохих 199 байгууллагаас 182 байгууллага буюу 91,5 хувь мэдээлсэн байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.5-д зааснаар Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалт улирал бүр мэдээлвэл зохих 129 байгууллагаас 128 байгууллага буюу 99,2 хувь нь мэдээлсэн байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.8-д зааснаар Тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт улирал бүр мэдээлвэл зохих 15 байгууллага мөн 100 хувь мэдээлсэн байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.9-д Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэл улирал бүр мэдээлвэл зохих 15 байгууллага 100 хувь мэдээлсэн байна.

2.2. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.4-т заасан мэдээллийг хуулийн хугацаа хоцроон мэдээлж байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д зааснаар тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг мэдээлвэл зохих 200 байгууллагаас 199 байгууллага буюу 99,5 хувь нь мэдээлсэн байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2-д зааснаар тухайн байгууллагын төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийг мэдээлвэл зохих 200 байгууллагаас 199 байгууллага буюу 99,5 хувь нь мэдээлсэн байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3-д Тендер, худалдан авалттай холбоотой мэдээллийг мэдээлвэл зохих 16 байгууллага 100 хувь мэдээлсэн байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-д зааснаар таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээллийг мэдээлвэл зохих 27 байгууллага 3522,5 сая төгрөгийн 232 гүйлгээг 100 хувь мэдээлсэн байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д зааснаар Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг мэдээлвэл зохих 32 байгууллага 13,635 сая төгрөгийн 735 гүйлгээг мэдээлж, Зэвсэгт хүчний 327 дугаар анги 180,1 сая төгрөгийн 12, Баянтүмэн сумын ИТХ 5,0 сая төгрөгийн 1, мөн ЗДТГ нь 17,2 сая төгрөгийн 2, цэцэрлэг нь 5,5 сая төгрөгийн 1 гүйлгээ нийт 207,8 сая төгрөгийн 16 гүйлгээг мэдээллээгүй байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д зааснаар таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээг мэдээлвэл зохих 21 байгууллага 21602,7 сая төгрөгийн 329 гүйлгээг мэдээлж, Зэвсэгт хүчний 327 дугаар анги 73,6 сая төгрөгийн 1 гүйлгээг мэдээллээгүй байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.6-д заасан Худалдан авалтын аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнг мэдээлвэл зохих 200 байгууллага 100 хувь мэдээлсэн байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.7-д заасан байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг мэдээлвэл зохих 200 байгууллагаас 197 байгууллага буюу 98,5 хувь мэдээлсэн байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасан Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг мэдээлвэл зохих 200 байгууллага 100 хувь мэдээлсэн байна.

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.9-д Хууль тогтоомжид заасан бусад мэдээллийг мэдээлвэл зохих 200 байгууллагаас 197 байгууллага буюу 98,1 хувийн биелэлтэй буюу Цөм сүрэг, Гурванзагал, Баянтүмэн хөгжил ОНӨҮГ-ууд мэдээллээгүй байсан.

Гурванзагал сумын ИТХ 54, ОНХС 58, сургууль 45, цэцэрлэг 30, эрүүл мэндийн төв 54, Баянтүмэн сумын ОНХС 34, сургууль 15, цэцэрлэг 16, Баян-Уул сумын ОНХС 34, Баяндун сумын ОНХС 33, Матад сумын ЗДТГ 12, сургууль 12, цэцэрлэг 11, ОНХС 30, Халхгол сумын ОНХС 30, сургууль 12, цэцэрлэг 12, Хэрлэн сумын ИТХ 75, ЗДТГ 39, Булган сумын цэцэрлэг 30, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар 45, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар 31, Хилийн цэргийн 0132 дугаар анги 21, Хилийн цэргийн 0198 дугаар анги 61, Дорнод Их сургууль 77, Байгаль орчин аялал жуулчлалын газар 17 мэдээллийг хуулийн хугацаанд тайлагналгүй хоцроон мэдээлсэн байна.

Хуулийн хугацаанд тайлагнаагүй хоцроон мэдээлсэн байгууллагуудад мэдээллээ хуулийн хугацаанд байршуулж байх аудитын зөвлөмж, арга зүйгээр ханган ажилласан.

2.3. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 6 дугаар зүйлийн 6.5-д заасан мэдээллийг мэдээлсэн үү.

Орон нутагт хамааралгүй болно.

2.4. Хуулийн 6.7 “Нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон бусад төрийн захиргааны байгууллага нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг тухайн этгээдийн овог нэрийн хамт цахим хуудсанд байрлуулан тухай бүр шинэчилж мэдээлнэ.” гэж заасныг мэдээлсэн үү.

ҮАГ-аас ирүүлсэн төлөвлөгөөний хавсралт судалгааны мягтанд нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авсан этгээдийн жагсаалтыг мэдээлэх тухай дурьдагдаагүй тул аудитад хамрагдаагүй болно.

2.5. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.8-д заасан мэдээллийг 7 хоногийн дотор мэдээлсэн үү.

Хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани Дорнод аймагт байхгүй байна.

2.6. Хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасны дагуу Цөм сүрэг, үржлийн төв нь мэдээллийг иргэн олон нийтэд хүргэх үүргээ хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 7.1.3-д “тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан” мэдээлнэ гэж хуульчилсны дагуу Дорнод аймгийн хэмжээнд Шилэн дансны цахим мэдээллийн санд 209 байгууллагын 418 мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан байна. Үүнээс Цөм сүрэг үржлийн төв цэс нээлгэсэн боловч мэдээллийг огт мэдээллээгүй нь иргэд олон нийтэд хүргэх үүргээ хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

III Бүлэг: Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу аймгийн ИТХ нь шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй байна.

3.1. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу аймгийн ИТХ нь шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 8.1-д “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн хурал ... хэрэгжүүлнэ.” гэж заасан хэдий ч аймгийн ИТХ-аас шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавиж ажиллаагүй байна.

3.2. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан этгээд хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т Энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ гэж хуульчилсны дагуу аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцын 132 байгууллагад 2,3 дугаар улиралд дотоод аудитын хяналтыг тавьж ажилласан байна.

Санхүүгийн хяналт, аудитын алба нь Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2016 онд хяналт шалгалтыг 2 удаа хийн аймгийн удирдах ажилтны шуурхай хуралдаан, орон нутгийн байгууллагуудын удирдлага, санхүү бүртгэлийн ажилтнуудад мэдээлэл тавьж, хуулийн хэрэгжилтийн тайлан, мэдээг Төсвийн Ерөнхийлөн захирагч болон Сангийн Яамны Төсвийн хяналт, эрсдлийн удирдлагын газарт улирал бүр хүргүүлжээ.

Дорнод аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцийн өрхийн эрүүл мэндийн 3 төвийн бүртгэл, тайлагналд хяналт тавигдаагүй байна.

Санхүүгийн хяналт, аудитын албаны хийсэн шалгалтаар 64 байгууллага хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн зөрчил нь аудитаар давтан гарч байгаа нь байгууллагуудын дотоод хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагын дүн:

Өмнөх аудитаар төрийн болон орон нутгийн өмчит огт мэдээллээгүй 4 байгууллагуудын холбогдох 8 албан тушаалтнуудад хуулийг хэрэгжүүлэх албан шаардлага өгснийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Аймгийн хэмжээнд шилэн дансны бүртгэлд байгууллага, аж ахуйн нэгжүүдийн 98,5 хувь нь хуулийн дагуу хамрагдсан байна.
2. Хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудад Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 96,7 хувьтай байна.
3. Хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагууд 6 дугаар зүйлийн 6.4-т заасан мэдээллийг 26 байгууллага хуулийн хугацаа хоцроон мэдээлж байна.
4. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу аймгийн ИТХ нь шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй байна.

Аудитаар нийт 281,4 сая төгрөгийн зөрчил илрүүлж зөрчлийг арилгах хугацаатай 10 албан шаардлагыг 10 байгууллагын 20 албан тушаалтанд хүргүүллээ.



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

21000, Чойбалсан, Дорнод аймаг
Утас: 7058-4202, факс: 7058-4584

2016.12.14 № 1/1897

танай _____ -ны № _____ -т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Б.БОЛОРТУУЛ ТАНАА

Үндэсний аудитын газрын нэгдсэн
төлөвлөгөө, удирдамжийн дагуу хийсэн нийцлийн
аудитын тайлантай танилцлаа.

Цаашид өгсөн зөвлөмжийн дагуу хянаж
ажиллах болно.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ Ч.ГАНБАТ

01 639

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

Аймгийн ИТХ-ын дарга Л.Хишигтогтох танаа:

1. Шилэн дансны тухай хуулиар хяналт тавих эрх бүхий аймгийн ИТХ нь эрхээ хэрэгжүүлэн ажиллах.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч М.Бадамсүрэн танаа:

1. Шилэн дансны цахим хуудсанд хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагууд хуульд заасан хугацаанд мэдээллээ бүрэн мэдээлж байх.
2. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах.
3. Аудитаар илэрсэн зөрчил, дутагдлыг давтан гаргахгүй байхад анхаарч, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2016 оны 12 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймгийн Аудитын газарт ирүүлэх.


АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.БОЛОРТУУЛ

БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР:  Д.НАРМАНДАХ

АУДИТОР:  Б.ОДХҮҮ

ШИНЖЭЭЧ:  Б.БАТЖАРГАЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
ДОРНОД АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2016 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 30


Чойбалсан хот

Нийцлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2014 оны 121 дүгээр тушаал, 2003 оны 53 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2, аймгийн Аудитын газрын удирдлагын зөвлөлийн 2016 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан төлөвлөгөөний дагуу "Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт"-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар өгсөн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсүгэй.
4. Нийцлийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор Д.Нармандахад даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

Аймгийн Тэргүүлэх аудиторын 2016 оны 12
дугаар сарын 14-ний өдрийн 30 дугаар
тушаалын хавсралт

Албан шаардлагын жагсаалт

2016.12.14

д/д	Байгууллагын нэр	Нийцлийн аудитын дугаар	Албан шаардлагын утга	Албан шаардлагын мөнгөн дүн
1	Матад сумын Засаг дарга	ҮАГ- НАГ/2016/04- НА/	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх	-
2	Халхгол сумын Засаг дарга	ҮАГ- НАГ/2016/04- НА/	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх	-
3	Баянтүмэн сумын Засаг дарга	ҮАГ- НАГ/2016/04- НА/	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх	27'855'500
4	Стандартчилал хэмжил зүйн хэлтэс	ҮАГ- НАГ/2016/04- НА/	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх	-
5	Гурванзагал сумын Засаг дарга	ҮАГ- НАГ/2016/04- НА/	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх	-
6	Цагаан-Овоо засаг дарга	ҮАГ- НАГ/2016/04- НА/	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх	-
7	Онон-Улз голын сав газрын захиргаа	ҮАГ- НАГ/2016/04- НА/	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх	-
8	Зэвсэгт хүчний 327-р анги	ҮАГ- НАГ/2016/04- НА/	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх	253'733'063
9	Хэрлэн сумын Засаг дарга	ҮАГ- НАГ/2016/04- НА/	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх	-
10	Цөм сүргийн үржлийн төв ТӨҮГ	ҮАГ- НАГ/2016/04- НА/	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх	-
Дүн				281'588'563